

ЯПОНЫ АРД ТҮМНИЙ АЖ АМЬДРАЛ
ОРЧИН ҮЕД

Б.Сэржав

Япон улс нийгэм эдийн засгийн салбар бүрийн тухайн жилийн хөгжлийн явц, цаашдын төлөв байдлыг үнэлж дүгнэсэн Хакушэ хэмээх Цагаан номыг жил тутам 30 гаруй төрлөөр хэвлэн гаргадаг. Түүний нэг нь Засгийн газрын дэргэдэх гол байгууллага-эдийн засгийн төлөвлөлтийн газраас эрхлэн нийтлэдэг "Ард түмний аж амьдралын цагаан ном" ("Кокумин сейгацу хакушэ") юм. Хөгжингүй Япон улсын ард түмэн өнөөдөр хэрхэн аж төрж байна, орон байрны хангамж ямар байна, сэтгэл хангалуун, чинээлэг амьдарч чадаж байна уу, үгүй юу гэх мэт олон асуудал бидэнд сонирхолтой байж болох юм. Эдгээр анхаарал татсан асуудалд ямар нэг хэмжээгээр хариулахын тул ард түмний аж амьдралын 1991 оны цагаан номын материалаас дурьдая.

Дайны дараа японы эдийн засаг үнс нурман дундаас гайхмаар үсрэнгүй хөгжиж ард түмний аж амьдралын түвшин дэлхийд урьд өмнө байгаагүй хурдтайгаар эрс дээшилсэн билээ. Сүүлийн хоёр жил гаруйг эс тооцвол Японы эдийн засгийн өсөлт 1986 оны 12-р сараас хойш тогтвортой байгаа бөгөөд энэ жилээс эдийн засаг дахин дээшилэх хандлагатай байна гэж судлаачид үзэж байна. Энэ удаагийн эдийн засгийн тогтвортой хөгжил нь Плаца-ийн тохиролцоо-(1985 оны 9-р сард Нью Йоркийн Плаца зочид буудалд 7 том гүрний сангийн сайд нар уулзаж америк долларын ханшны талаар хэлэлцэж тунхаг гаргасан хурлыг Плаца-ийн тохиролцоо гэдэг)-ноос хойш эндака (японы иений ханш дээшлэх үзэгдлийг ингэж нэрлэдэг -Б.С.)-ийн нөлөөгөөр бий болсон эдийн засгийн бүтцийн шинэчлэлийн үйл явцтай хугацааны хувьд давхцаж байгаа бөгөөд хувь хүний зарлага, тоног төхөөрөмжийн нийлүүлэлт зэрэг дотоодын хэрэглээ өргөжсөн явдал гол хүчин зүйл нь болж өгсөн юм.

Эндака 1985 оны 9-р сараас хойш үргэжлэн Японы эдийн засагт бүтцийн шинэчлэлт дараах байдлаар явагджээ.

Юуны өмнө эндака нь экспортын чиглэлийн үйлдвэргүүдэд сөрөг нөлөө үзүүлж, урьд нь гадаад зах зээлийн зориудалттай явагдаж байсан нийт үйлдвэрлэлийн нийт ажиллагааг дотоодын хэрэгцээг хангах чигт өөрчилсөн.

Мөн импортын бараа түүхий эдийг худалдан авах үнэ харьцангуй хямдарсан нь гаднаас оруулах импортыг нэмэгдсэн нэмэгдүүлэв. Энэ нь эдийн засгийн өсөлтөд нөлөөлсөн голлох хүчин зүйл болжээ. Нөгөө талаар төрөл бүрийн хөрөнгө оруулалт идэвхжиж, цар нь ч үлэмж нэмэгдэв. Ялангуяа орон сууцны салбарт хөрөнгө оруулалт өсч, санхүү зээлийн салбар улам тогтвортой болжээ. Энэ бэлхий үр дүнд эдийн засаг нь дотоодын хэрэгцээг голлосон чиглэлээр хөгжиж, дефицит ч буурч эхэлжээ. 1986 оноос хойших 4 жилийн турш эдийн засаг жил тутам дундажаар 4-6 хувь, түүний дотор дотоодын эрэлт хэрэгцээг хангах чиглэлийн салбар 5,5 хувиар өсөв.

Эдийн засгийн өсөлтийг ийнхүү харьцангуй удаан хугацаагаар тогтвортой байлгаж чадсаны үндсэн дээр юуны өмнө нийгмийн доторхи өрхийн орлого тогтмол нэмэгджээ. Түвтэй уялдаатайгаар нийгмийн гишүүдийн эрэлт хэрэглээ нэмэгдсэн байна. Нөгөө талаар энэ хугацаанд үнийг тогтвортой байлгаж, хувь хүний хуримтлалыг ахиулж чаджээ. Судалгаанаас үзвэл өрхийн тэргүүн нь аль нэгэн байгууллага, үйлдвэрт хөдөлмөрлөж байгаа ажилчин өрхийн сарын дундаж бодит орлого 1991 он гэхэд 526918 иен буюу тухайн үеийн ханшаар ойролцоогоор 4180 ам. доллар болсон нь өмнөх оныхоос 1,9 хувь өсчээ. Энэчилэн ажилчин, хувиараа хөдөлмөр эрхлэгч, тариачин өрх гэх мэтээр ангилан тэдгээрийн нийгмийн даатгал, төрөл бүрийн татавар зэрэг зайлшгүй зарлагыг хасахад хувь хүн, өрхийн зарлагын аль алин нь нэмэгдэж, бодит орлогынх нь хэмжээ зарлагаасаа ямагт өндөр байж чадсан байна.

Орлого, зарлагын өсөлт, бууралт нь үнийн өөрчлөлттэй салшгүй уялдаатай байдаг. 1986 оны сүүлчээс 1992 оны 6-р сар хүртэл үнийн өсөлт жилд 2,1 хувь байсныг эдийн засаг сайн байсан үүний түрүүчийн 1983 оны эхээс 1985 оны дунд тө хүртэлх үеийн 2,4 хувийн өсөлт, түүний өмнөх 1977 оны сүүлчээс 1980 оны эхэн хүртэлх 4,8 хувийн өсөлттэй харьцуулбал хэвийн тогтвортой өсөлт ажээ.

1991 оны хувьд цаг агаарын тогтворгүй байдлаас шалтгаалж хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн түүний дотор хүнсний ногоо, Ирак-Кувейтийн хямралаас шалтгаалж нефтийн бүтээгдэхүүний үнэ хамгийн их өсчээ. Гэвч нефть шатахууны үнийн өсөлт сөрөг нөлөөлөл багатай байжээ. Яагаад гэвэл тухайн үеийн өсөлтийн, өмнөх хоёр удаагийн нефтийн хямралаас ялгаатай нь иений ханш эрс дээшилж байх үед тохиолджээ. Тухайлбал нефтийн үнэ өссөн 1991 оны 4-р сард 1 ам. доллар 158 иентэй тэнцэж байсан бол мөн оны 11-р сар гэхэд 1 ам. доллар 129 иен болж иений ханш эрс дээшилсэн юм. Ханшны ийм өсөлттэй уялдан иенээр худалдан авах нефтийн үнийн өсөлт сөрөг нөлөө багатай байлаа. Сүүлийн жилүүдийн үнийнбайдлыг тоймлон үзэхэд аж үйлдвэр, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн, үйлчилгээний салбарын үнийн өсөлт бусад салбартай харьцуулахад нэлээд өндөр байжээ.

1990 онд 30-аас дээш ажиллагсадтай аж ахуйн нэгжид нэг ажилчинд дундажаар сард 372390 иенийн цалин олгосон нь өмнөх оныхтой харьцуулахад 4,6 хувиар нэмэгджээ. Өмнөх оныхтой харьцуулахад тогтмол цалингийн хэмжээ 4,0 хувиар, шагнал урамшлын мөнгөний хэмжээ 6,1 хувиар өсчээ. Ялангуяа барилга, тээвэр, холбооны салбарт урамшилт цалингийн хэмжээ бусдаас өндөр байв. Дашрамд тэмдэглэхэд японы пүүс, албан байгууллагуудад ажиллагсад жилд зун, өвлийн улиралд хоёр удаа урамшилт цалин авдаг бөгөөд байгууллагын ашгаас шалтгаалан янз бүр байх хэдий боловч нэг ажилчин жилд урамшилт цалинтай хамт дундажаар 17 сарын цалин авдаг ажээ. Нийт үйлдвэрт ажлын цаг гурван жил дараалан буурсны үр дүнд 1991 оны байдлаар 2044 цаг болсон нь хөгжингүй орнуудын жилийн ажлын цаг Америкт 1924, Англид 1938, Германд 1655, Францид 1643 байгаатай харьцуулахад (энэ үзүүлэлт 1986 оны тоо, 1986 онд Японд 2150 цаг байсан) 200-500 цагаар урт байна. Жил бүрийн хаврын тэмцлийн үеэр байнга тавигддаг гол шаардлага нь ажлын цагийг богиносгох, цалинг нэмэгдүүлэх асуудал юм.

Сүүлийн жилүүдийн шаргуу шаардлагын үр дүнд 46 цагийн системтэй байсан долоо хоногийн ажлын цагийг 1991 оны 4-р сараас эхлэн 44 цаг болгохоор шийдвэрлэсэн юм.

Япон улсын Хөдөлмөрийн яамны судалгаагаар 1990 оны 12-р сарын байдлаар долоо хоногт хоёр өдөр амардаг ажилчдын тоо нийт ажиллагсдын 86,4 хувьд хүрсэн байна. Үйлдвэрүүдийн дунд хамгийн олон цагаар ажилладаг голдодог 30-99 хүнтэй жижиг үйлдвэрүүдэд ч ажиллагсдын 62,5 хувь нь долоо хоногт хоёр өдөр амардаг болжээ. Дэлгэцтэй амралтын өдрийн тухайд гэвэл 1989, 90 онд нэг онд 15,5 өдөр ноогдож байснаас 8,2 өдрийгхамарсан дүн гарчээ.

Одоо нийгмийн доторхи янз бүрийн насны гишүүд өрхийн зарлага түүний онцлогийн талаар авч үзье. 80-аад оны эхэн үед Японы эдийн засаг тогтвортой өссөн хэсэг хугацааны гол онцлог нь Америкийн эдийн засаг сэргэсэнтэй уялдан экспортын ханш өсч, иений ханш бага байснаас Япон улсын экспортын хэмжээ эрс дээшилсэн өөрөөр хэлбэл гадаад зах зээлийн хэрэгцээнд голлон түшиглэсэн үе байлаа. Тэгвэл 1986 оноос хойших энэ удаагийн эдийн засгийн өсөлтөөс шууд шалтгаалан айл өрхийн зарлага нэмэгдсэн, өөрөөр хэлбэл дотоодын эрэлт хэрэглээ ихэд өргөжсөн явдал юм. Тухайлан Токиогоор төвлөсөн нийслэлийн дүүргүүдийн зах зээлийн эрэлт хэрэглээ эрс нэмэгдэж улмаар орон нутгийн том хотуудыг ч хамарч цар хүрээ нь тэлэн өргөжсөн онцлогтой.

Судалгаанаас үзвэл 1990 онд нийгмийн нийт гишүүдийн зарлагын хэмжээ нийтдээ өсч, ялангуяа өрхийн тэргүүн нь 50-иад настай өрх, дээд сургуулийн насны хүүхэдтэй өрх, хувийн орон сууцтай айл өрхийн зарлагын хэмжээ хамгийн их байжээ. Тухайлбал өрхийн тэргүүн нь 50-иад насны айлын нийт зарлагад боловсролын зардал 28,4 хувь болж, өмнөх оньхоос хамгийн их өсөлттэй байв. Учир нь ийм өрх голдуу дээд сургуулийн оюутан хүүхэдтэй байдаг. Ялангуяа сургуульд сургах, ажил эрхлүүлэхээр хүүхдээ том хотуудад явуулдаг өрхөд зардлын голыг үр хүүхэддээ илгээх мөнгө эзэлдэг. Хичээлийн төлбөрийг оролцуулаад нэг хүүхдэд эцэг эх нь сард дундажаар 149400 иен илгээж байгаа нь таван жилийн өмнөхтэй харьцуулахад 24,5 хувь өсчээ. Энэ баримт нь Японд айл өрх бүр үр хүүхдээ боловсрол мэргэжил эзэмшихэд маш их мөнгө зарцуулдагийг харуулж байна.

50-иад насны гэр бүлийнхний худалдан авсан гол бараа нь автомашин, цахилгаан техникийн бараа, боловсролын бараа таваар байна. 40-50 насны айл өрхийн 80 гаруй хувь нь нэгээс дээш автомашинтай, 3 өрхийн нэг нь 2-оос дээш автомашинтай ажээ. Энэ мэтчилэн 40-50 насны гэр бүлд тээвэр холбоо, боловсролд зарцуулах зардал маш өндөр байдаг ажээ. Мөн гэрийн тавилга, хувцас хунарт зориулах зарлагын хэмжээ их өсч байна. Хүн амын дотор хамгийн их зарлагатай нь нэгдүгээрт, 50-иад насны үеийнхэн, хоёрдугаарт, Токио, Осака, Нагояагийн гурван том хотод амьдарч байгаа хувийн орон сууцтай 30 хүртэлх насны залуу айл өрх байсан нь хувийн орон сууцтай болохын тулд их хэмжээний мөнгө зээлж авдаг, тодорхой хугацаанд түүнийг буцаан төлдөг явдалтай холбоотой ажээ.

Энд тэмдэглэхэд 70-аас дээш насныхны зарлагын гол нь чөлөөт цагаа өнгөрөөх, эрүүл мэндийн даатгал, эмчилгээ, тээвэр холбоонд зориулагддаг байна. Энэ насныхан идэвхтэй амьдралыг илүү их эрхэмлэж, ялангуяа үзвэр, зугаалга зэргийн билет, спортын болон бусад тоног төхөөрөмж ашигласны үнэ, чөлөөт цаг өнгөрөөх төрөл бүрийн үйлчилгээний үнэ өссөн ч гэсэн мөнгөө түүнд зарцуулсаар байна. Хүн амын дотор зарлага ихтэй дөрөвдэх бүлэг хүмүүст ажил эрхлэж буй 30 хүртэлх насны эмэгтэйчүүд ордог юм байна.

Ялангуяа дээр дурьдсан гурван том хотод амьдарч ажиллаж буй ганц бие эмэгтэйчүүдийн хувьд орон сууцны үнэ, хувцас, тээвэр, холбоо, гоо сайхны зүйлийн зардал өндөр байгааг судалгаа харуулжээ. Хувь хүн, өрхийн зарлагын талаар тоймлон өгүүлэхэд ийм байна.

Японд сүүлийн үед анхаарал тавьж байгаа өөр нэг асуудал бол нийслэл Токио хотод хүн ам, үйлдвэрүүд хэт төвлөрөх хандлага улам хүчтэй болж байгаа явдал юм. Энэ үйл явцын тухай товчхон өгүүлье.

Хүн ам, эдийн засгийн механизм Токиод төвлөрөх үйл явц дайнаас хойших бүх үед жигд хурдтай явагдсангүй. Энэ нь дайны дараах хүнд бэрх жилүүд, жигд өндөр хөгжлийн үе (1955-1965), нефтийн хоёр удаагийн хямрал (1973, 1978), цаашлаад сүүлийн үеийн эдийн засгийн удаан хугацааны

олгоортой байдал гэхчилэн үе тус бүрийн онцлогтой нягт холбоотой.

Одоо Токиод нийтдээ 11 сая гаруй хүн оршин сууж, нэг квадрат дөрвөлжин км бүрт 16000 оршин суугч ноогдож байна. Японы хүн амын 25,7 хувь нь Токио, түүний дагуул хотуудад амьдарч байна. Хөгжингүй орнуудын нийслэлд, тухайлбал Нью Йоркт хүн амын 8,9 хувь, Лондонд 23 хувь Парист 18,8 хувь нь амьдардаг ажээ. Өөрөөр хэлбэл хөгжингүй орнуудын нийслэл хотуудын дунд хүн амын нягтралаараа Токио хамгийн дээгүүрт орж байна.

Сүүлийн үед Токио хотын захын дүүрэг, ойр хавийн мужуудын хүн амын нягтрал маш өндөрсөх хандлагатай болжээ. 1991 он гэхэд Японы хамгийн их ашиг орлоготой 300 үйлдвэр компанийн 326 нь, хамгийн том 100 компанийн 72 нь Токиод төв захиргаагаа байгуулжээ. Ер нь хэмжээгээр томоохон, ашиг орлого ихтэй үйлдвэр компаниуд голдуу Токиод төвлөх хандлага ихэсч байна. Улс ардын аж ахуйн салбараар авч үзвэл аж үйлдвэрийн салбарын ажиллагсдын 25,1 хувь, санхүү даатгалын салбарын ажиллагсдын 34,3 хувь, үйлчилгээний салбарын ажиллагсдын 30,1 хувь нь зөвхөн Токио хотод амьдарч ажиллаж байна. Ялангуяа үйлчилгээний салбараас мэдээлэл, реклам сурталчилгааны салбарын ажиллагсдын 49,0 хувь нь Токиод ажиллаж байна.

Энэ бол Токио дахь мэдээллийн төвлөрөл, түүний эрэлт зэрэгцээ аль зэрэг байгааг харуулах баримт юм. Энэ нягтчилэн хүн ам, эдийн засгийн үйл ажиллагаа Токиод төвлөрөх үзэгдэл гүнзгийрч байна. Эдийн засгийн жигд хөгжлийн жилүүд, өөрөөр хэлбэл 1955-1965 оны үед хүн ам, бараа материалын хөдөлгөөнд үндэслэсэн зөвхөн Токиод төдийгүй бусад том хотууд руу чиглэсэн олон туйлт төвлөрөл явагдсан бол өнөөдөр валют санхүү болон түүнийг дагалдсан мэдээлэл, үйлчилгээ зэрэг салбарын Токио руу хандсан нэгэн туйлт төвлөрөл болж байна гэж судлаачид тэмдэглэжээ.

Хүн ам төвлөрөх нэг хүчин зүйл нь дээд сургуулийн насны залуус Токиод цугларч суурьших явдал ажээ. 1992 онд Токиогийн дээд сургуулиудад элсэгчдийн тоо улсын бус сургуульд элсэгчдийн 41,4 хувийг эзэлжээ.

Мөн Токиод төрөл бүрийн мэргэжилийн сургуульд элсэгчдийн тоо 1992 онд 260 мянгад хүрч дээд сургуульд элсэгчдээс давжээ.

Түүнчлэн дээд сургууль төгсөөд ажил сонгох боломж Токиод давуутай байдаг тул залуучууд олноор суурьших хүчин зүйл болж байна.

Японы хүн ам хотод төвлөрөх, ялангуяа Токиод төвлөрөх хандлага дээр үеэс анхаарал татаж иржээ. Токио руу хүн ам олноор урсан орж, бүс нутгийн ялгаа ихэссэнтэй холбогдон түүхэн хөгжлийн үе шат бүрд зохицсон бодлого боловсруулан хэрэгжүүлсээр иржээ. Энд жишээлэн 70-аад оноос хойш хэрэгжүүлж ирсэн зохицуулалтын төлөвлөгөөний талаар товч үзье.

1977 оны " Улс орныг цогцолбороор хөгжүүлэх шинэ төлөвлөгөө" нь баялгийг үр ашигтай хуваарилах төдийгүй, хязгаарлагдмал баялгийг бодолцон бүс нутгийн онцлог, уламжлалт соёлыг хүндэтгэн, байгаль болон хүний экологийн тэнцвэрийг хангасан аж амьдралын орчинг бий болгох явдлыг гол зорилго болгожээ. Ийм байдлаар хүн ам, аж үйлдвэр том хотод төвлөрөх үйл явцыг хязгаарлаж, нөгөө талаар орон нутгийг хөгжүүлэн, хүн ам хэт сийрэгжих, нягтрах явдлыг зохицуулахаар заажээ.

Жигд өндөр хөгжлийн жилүүдэд гурван том хот руу хүн ам урсах явдал намжих, орон нутагтаа суурьшин нутгаа хөгжүүлэх хөдөлгөөн өрнөж, тэнд амьдрал сайжирсан юм. Гэвч интеграцчилал идэвхжиж, мэдээллийн ач холбогдол өсч, улмаар мэдээллийн гол төвийн утгаараа Токиогийн байр суурь дээшилж, 70-аад оны сүүлийн хагасаас эхлэн Токиод төвлөрөх үйл явц дахин бий болжээ. Гадаадын үйлдвэрүүд орж ирсэн, мэдээлэл, өргөжсөн, боловсрол дээшилсэнтэй уялдан Токиод албан газрууд захиргаагаа нээж эхэлснээр Токиод газрын үнэ эрс өссөн юм. Энэ нь улс даяар газрын үнэ өсөхөд хүргэжээ.

1987 онд Улс орныг цогцолбороор хөгжүүлэх дөрөв дэх удаагийн төлөвлөгөөт зорилтыг дэвшлүүлэн тавив. Энэ төлөвлөгөөний стратегийн үндсэн зорилго нь бүс нутгийг хөгжүүлэх асуудлыг энэ тэргүүнд тавьж, бүс нутгийн хоорондын холбоо харилцаа, зам тээврийн нөхцөлийг

сайгаруулах явдал байв. Үйлдвэрүүдийг тараан жигд байршуулах бодлого үр дүнд хүрч, улс даяар аж үйлдвэр нэгдэж хөгжжээ. Мөн нийгмийн баялгийн тэгш бус суваарилалтад ч зохих хэмжээгээр анхаарч зарим салбарын хувьд орон нутагт илүү их хэмжээний хөрөнгө оруулалт хийсэн байна. Гэсэн хэдий боловч Токиод төвлөрөх үйл явц иргэдчилсээр л байна. Энэ нь дараах шалтгаантай нягт холбоотой юм. Дайнаас хойш Японы эдийн засаг төсөөлж байснаас зүйрлэшгүй хурдтай хөгжсөн явдал нэг үндсэн шалтгаан нь юм. Эдийн засгийн ийм хөгжил нь түүнтэй эн гэдгүү хурдтайгаар явагдсан Токиод төвлөрөх үйл явцыг сайгаруулах бодлогыг эцсийн бүлэгт төдий л үр дүнд иргэдэггүй юм.

Түүний дээр 70-аад оны үеийн аж үйлдвэрийн бүтцийн нэгдсэн өөрчлөлтийн явцад төвлөрөлийг тараах бодлого ч хангалттай нөлөөлж чадаагүйтэй холбоотой. Аж үйлдвэрийг орон нутагт байршуулах бодлого нь ажиллах эрч хөлслөлтийг нэмэгдүүлэхэд үр дүнд хүрсэн хэдий боловч, үйлдвэрлэлийн мэдээлэл, үйлчилгээг нэмэгдүүлэхэд үр ашигтай байж чадаагүй болохыг судалгаа харуулсан байна. Төвөөс удирдаж явуулсан орон нутгийг жигд хөгжүүлж, төвлөрөлийг тараах бодлогын явцад олон бус нутаг янз бүрийн төслийг хэрэгжүүлэхэд туслалцаа хэсэний улмаас хөрөнгө оруулалт тарамдаж анхны төсөөлж байсан үр дүнд хүрч чадаагүй тал байжээ.

Токио хотын амьдралын сайн тал, бэрхшээлтэй талыг олон нийтийн санал асуулгын үндсэн дээр судалж үзсэн байна. Токио хотод амьдрахад хамгийн тохиромжтой сайн талууд гэвэл "зам тээвэр, харилцаа холбоогоор бусад хотоос давуу", "дэлгүүрээс юм худалдаж авахад барааны нэр төрөл нь олон", "эмнэлгийн байгууллагууд нь сайн" гэж хотын үндсэн иргэд хариулсан байхад орон нутгийн иргэд Токио нь "ажил хөдөлмөр эрхлэх боломж нөхцөл сайн", "хүмүүсийн хоорондын харилцаанд боогдох явдал байхгүй" гэсэн хариулт зонхилжээ. Токиогийн амьдралын бэрхшээлтэй талын тухайд "орон байр давчуу", "орон сууцны үнэ өндөр" гэсэн санал зонхилжээ.

Токиод хүн ам төвлөрөх үзэгдэл нь эдийн засгийн үйл ажиллагааг төвлөрүүлэхийн зэрэгцээ эрчим хүчээр хангах,

хог хаягдлыг боловсруулах, усны нөөцийг зохицуулах зэрэг асуудлыг үүсгэн, зам харилцааг хүндрүүлж, агаар орчныг

бохирдуулан, хотын амьдралын зохистой хэм хэмжээг бусниулах нэгэн үндэс болж байна. Токио хот түүний дагуул хот, дүүргүүдэд газрын үнэ эрс өссөнөөс хувийн орон сууц худалдан авах өрхийн тоо цөөрчээ. Токиогийн хувийн орон сууцтай өрхийн ихэнх нь үе залгамжлан өвлөн авсан гэр бөгөөд газрын үнэнээс шалтгаалан цаашид ч зөвхөн хөдөлмөрийн орлогоор хувийн сууцтай болох боломж байхгүй гэдгийг судалгаа харуулсан байна.

Токиод орон сууцны асуудлыг хүндрүүлж байгаа хэд хэдэн шалтгаан байгаа нь нэгд, аж үйлдвэрийн бүтцэд гарсан өөрчлөлт, мэдээллийн системийн хөгжилтэй уялдан Токио түүний дагуул хот, дүүргүүдэд албан байгууллагууд ихээр бөөгнөрсөн явдал юм. Албан газруудын захиргаа нэг дор бөөгнөрөх нь оршин суугчдыг хотын зах руу шахаж, ажил албандаа ирж очих болон орон сууцны холбогдолтой олон төрлийн асуудлыг бий болгож байна. Ингэж албан байгууллагуудын захиргаадын төвлөрөх нь хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлж ажилд орогсод болон тэдний гэр бүлийнхэнд орон сууцны шаардлага шинээр үүсгэдэг байна. Хоёрт, албан байгууллагын конторын хэрэгцээ ихсэх тусам газрын үнэ нэмэгдэж энэ нь орон сууцны эдэлбэр газрын үнэнд мөн нөлөөлж байна.

Токио мэтийн том хотуудад газрын үнэ өндөрссөн нь хотын төвийн дүүргүүдэд жирийн ажилчин албан хаагч нар хувийн тусдаа орон сууцтай болох боломжийг алдагдуулж байна. Цаашилбал хотын төвөөс алслагдсан газарт амьдарч тэндээс олон цаг зарцуулан ажилдаа ирж очих явдал сүүлийн үед улам ихсэх хандлагатай байна.

Токиод төвлөрөх үзэгдлийн үр дагавар нь юу байв гэвэл Токиод нийгэм эдийн засгийн бүх үйл явц төвлөрөх үзэгдэл нь эдийн засгийн асар өндөр хөгжлийг бодит байдалд хэрэгжүүлж, нийт ард түмэн тодорхой хэмжээний өндөр түвшинд амьдрах нөхцлийг бий болгоход хамгийн ашиг тусаа өгсөн тогтолцоо байжээ гэж дүгнэж үзэж болох юм. Юуны өмнө японд аж үйлдвэрийн үндэс суурь, эдийн засгийн үндэс суурийг бий болгож, үйлдвэрлэлийн хүчин

чадлыг дээшлүүлнэ. Үүн дээр үндэслэн ард түмний аж амьдралыг баян чинээлэг болгоно" гэсэн үзэл санааг улс зачараа өөрөөр хэлбэл ард түмэн ч, засаг төрийнхөн ч, мөнгө санхүүгийнхэн ч баримталж ийм чиг баримтлалаар түүхий эд, хөрөнгийг ашигтай байдлаар хуваарилж мэдсанаар ард түмний материаллаг аж байдал өндөр түвшинд хүрчээ. Ийм эерэг үр дагаварыг Токиод төвлөрөх үйл явц бий болгожээ.

Тэгвэл Токиод төвлөрөх үйл авцын үр дүнд тэнд амьдралын өртөг ихээхэн өсч, амьдралын нөхцөлд сөрөгөөр нөлөөлсөн тал бас бий. Ялангуяа газрын үнийн асар их өсөлтөөс өнөөдөр Токиод хувийн орон сууцгүй хүмүүс, мөн цаашид Токиод орж ирэгсэд ажиллаж буй албан байгууллагатаа ойр газарт хувийн сууц барихад ихээхэн хандралтэй болж байна. Түүний дээр сайн чанарын хөлсний байр цөөн хөлсний байранд амьдрагсад нь маш өндөр хөлсөөр давчуу байранд амьдрахад хүрч байгаа ажээ. Мөн Токиод ажиллагсдын оршин суугаа газар, ажлын байр хоёр улам холдож байгаагаас ажилдаа ирэх, очих хугацаа уртасч, нийтийн унааны шахцалдаан зэрэг нь хөдөлмөрчдөд хандрал учруулж байна. Энэ нь ажлын алжаалаа тайлах, гэр эрхэндөө өнгөрүүлэх цагийг багасгасаар байгаа сөрөг тал ч байна. Эцэст нь тэмдэглэхэд японы ард түмэн орчин үед аж амьдралын олон үзүүлэлтээрээ дэлхийд тэргүүн байранд орж байна. Зөвхөн ганц жишээ дурьдахад 1960 онд японы хүн ам тутамд ноогдох бодит орлогын түвшинд америкийн хүн ам тэтгэлтийн 15 хувьтай тэнцэж байсан бол 1970 он гэхэд тэрхүү ялгаа 40 хувь болж буурчээ. Улмаар 1990 он гэхэд америкийн хүн ам тутамд ноогдох бодит орлого японь энэ үзүүлэлтийн 90 хувьтай тэнцэх болжээ.

Эдийн засгийн асар түргэн хөгжил, ард түмний аж амьдралын өндөр түвшинг бодитойгоор хэрэгжүүлж ирсний тул энэ нь японы засгийн газар аливаа тулгамдсан асуудлыг шийдвэрлэх, эдийн засаг нийгмийн хөгжлийн цаашдын төлөвийг тодорхойлохдоо дэлхийн хөгжлийн эрөнхий хандлага болон олон улсын эдийн засаг улам бүр интернациональчилагдаж ирсэн түүхэн үйл явцыг ямагт үндэслэн мэдэрч, улс орныхоо хөгжлийг түүнтэй нягт үйлдүүлэн зохицуулж чаддагт байгаа болов уу.

Ном зүй

Кокумин сэйгацу хакушё. Хэйсэй 3 нэнбан (Ард түмний аж амьдралын цагаан ном. Хэйсэй 3 он. Токио, 1991 он.

Кокумин сейгацу хакушё. Хэйсэй 4 нэнбан (Ард түмний аж амьдралын цагаан ном. Хэйсэй 4 он.), Токио, 1992 он.

Нихон (Япон улс) Токио, 1989 он.

Нихон кэйзай хакушё. Хэйсэй 4 нэнбан (Японы эдийн засгийн цагаан ном. Хэйсэй 4 он) Токио, 1992 он.

Гэндай ёого-но киси чишики 1992 (Орчин цагийн нэр томъёоны үндсэн мэдлэг. 1992) Токио, 1992 он.

Кэйзайгаку житэн (Эдийн засгийн толь бичиг) Токио, 1992 он.

Нихон кэйзай зүсэцү (Японы эдийн засгийн тухай график, тайлбар) Токио, 1989 он.